"МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБОО"
БАТЛАВ:
ТЭРГҮҮН ..... А.БАТДАВАА

2026 оны 06 дугаар сарын 18 өдөр

ПАРАГЛАЙДЕРЫН НИСГЭГЧИЙН ТҮВШИН ТОГТООХ, ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмаар "Монголын Параглайдингийн Холбоо" /цаашид МПХ гэх/-ийн гишүүд, параглайдерын нисгэгчдийн ур чадварын түвшинг тогтоох, үнэлгээ хийх, нисгэгчийн үнэмлэх шинээр болон шинэчлэн олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2 МПХ-ний гишүүн клубын нисгэгчид болон гишүүн хувь хүн энэхүү журмын дагуу ур чадварын түвшингээ тогтоолгон, нисгэгчийн үнэмлэх авч болно. 6 сараас дээш хугацаагаар идэвхгүй байгаа нисгэгч ур чадварын буюу түвшин тогтоох шалгалт дахин өгч, нисгэгчийн үнэмлэхээ шинэчлэн авна.

1.3 Монгол Улсад агаарын чөлөөт нислэг үйлдэх нисгэгч бүрээс ур чадварын түвшинг нь илэрхийлэх нисгэгчийн үнэмлэх заавал авсан байхыг шаардана. Энэхүү шаардлага нь Монгол Улсын ИНЕГ-с Иргэний Нисэхийн Дүрэм-149 болон агаарын орон зай, чөлөөт нислэгийг зохицуулдаг бусад дүрэм, журмуудтай нийцсэн болохыг МПХ батална.

ХОЁР. НИСГЭГЧИЙН ТҮВШИН ТОГТООХ

2.1. Эхлэн суралцагч болон дунд шатны нисгэгчийн түвшинг тухайн нисгэгчийн инструктор, сургагч багш, харьяалагдаж буй клуб нь тогтооно. Ингэхдээ Хавсралт 1 буюу "Параглайдерын нисгэгчийн түвшин тогтоох үнэлгээний систем"-ийн "P1- эхлэн суралцагч" ба "P2- шинэ нисгэгч", "P3- дунд шатны нисгэгч" шатлалд заасан мэдлэг, ур чадварын шалгууруудыг баримтлан онолын шалгалтыг бичгээр авч, ур чадварын үнэлгээг хийж, Хавсралт №2-т байгаа үнэлгээний хуудсыг бөглөн МПХ-д ирүүлнэ. Онолын шалгалт авсан материал, багшийн өгсөн үнэлгээ, нисгэгчийн анкет, хариуцлагаас чөлөөлөх тухай мэдэгдэл эх хувиар, нислэгийн бүртгэл (log), сургалтын сертификат, сургалтын гэрээний хуулбарыг МПХ-нд ирүүлнэ.

2.2. Ахисан шатны нисгэгчийн түвшинг МПХ-с томилсон инструкторын зөвлөл, онолын шалгалт болон ур чадварын шалгалт (хамтдаа Түвшин тогтоох шалгалт) авсны үндсэн дээр тогтооно. "Параглайдерын нисгэгчийн түвшин тогтоох үнэлгээний систем"-ийн "P4- ахисан шатны нисгэгч" шатлалд заасан мэдлэг, ур чадварын шалгууруудыг баримтлан онолын шалгалтыг бичгээр авч, ур чадварын үнэлгээг хийж, нислэгийн бүртгэл (log) болон Хавсралт №2-т байгаа үнэлгээний хуудсыг үнэн зөв бөглөнө. Шалгалтын комисс 3-с доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд комиссын 2/3-ын саналаар "Тэнцсэн", эсвэл "Тэнцээгүй" гэсэн үнэлгээг өгнө.

2.3. Мастер нисгэгчийн түвшинг МПХ-с томилсон инструкторын зөвлөл 5 хүний тодорхойлолт болон нислэгийн бүртгэл (log)-ийг МПХ-с томилсон зөвлөл магадлан үзэж, МПХ-ний Удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ. Ингэхдээ Хавсралт №1 буюу "Параглайдерын нисгэгчийн түвшин тогтоох үнэлгээний систем"-ийн "P5- Мастер нисгэгч" шатлалд заасан бүх шаардлагуудыг ханган биелүүлсэн эсэхийг шалгаж, оноогоор дүгнэнэ.

2.4. Инструкторын зөвлөлд МПХ-ийн лицензтэй сургагч багш, дасгалжуулагч нар багтсан байна. Зарим нисгэгч нар хөндлөнгийн ажиглагчаар томилогдож болох бөгөөд тэд өөрийн түвшнээс дээгүүр түвшний бичгийн шалгалт, ур чадварын үзлэгийг явуулахад туслах маягаар оролцож болно. Мөн өөрийн нэгэнт эзэмшсэн шатны ур чадварыг дүгнэхэд шалгагчаар оролцож болно.

2.5. Түвшин тогтоох шалгалт жилд 2 удаа явагдах бөгөөд МПХ-с шалгалтын товыг тогтоож, шалгалт болохоос нэг сарын өмнө клубүүдэд албан бичгээр мэдэгдэх, мөн МПХ-ийн вэбсайт, олон нийтийн сүлжээ болон бусад хэрэгслээр түгээнэ. Клубүүд шалгалт болохоос 7 хоногийн өмнө түвшин тогтоох шалгалтанд орох нисгэгчдийнхээ нэрсийг МПХ-с томилсон инструкторын зөвлөлд ирүүлнэ.

2.6. Инструкторын зөвлөлийн нисгэгчийн зэрэг тогтооход тухайн нисгэгч өөрөө санал хураалтад оролцохгүй, МПХ-ны нарийн бичиг санал өгнө.

ГУРАВ. ҮНДЭСНИЙ НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ

МПХ нь нисгэгчийн үнэмлэхийг дараах байдлаар олгоно. Үүнд:

3.1 Энэхүү журмын 2.1–2.6-д заасны дагуу “Параглайдерын нисгэгчийн түвшин тогтоох үнэлгээний систем”-ийн аль нэг шатны шалгуурыг хангаж, мэдлэг, ур чадварын үнэлгээ хийлгэсэн нисгэгч нарт нисгэгчийн үнэмлэх шинээр болон шинэчлэн авах эрх үүснэ.

3.2 Үнэмлэх авах эрх үүссэн нисгэгч нар Хавсралт №3-т байх өргөдлийн маягтыг бөглөж, түүний арын нүүрэнд байх МПХ болон түүний гишүүн байгууллагуудыг хариуцлагаас чөлөөлөх тухай мэдэгдлийг сайтар уншиж танилцсаны дараа гарын үсэг зурна.

3.3 Үнэмлэх шинээр болон шинэчлэн авах өргөдлийн хамт мэдлэг, ур чадварын үнэлгээний хуудас, нислэгийн бүртгэл, нэг хувь цээж зургийг харьяалагддаг клубээрээ дамжуулан МПХ-ний нарийн бичгийн даргад ирүүлнэ.

3.4 Нисгэгчийн үнэмлэх буюу англиар “National Pilot License” гэж нэрлэгдэх үнэмлэхийн загварыг /Хавсралт №5/ МПХ-ний Удирдах зөвлөл батална. Олон улсад зөвхөн FAI-н IPPI картын хамт байх тохиолдолд хүчинтэй байна. Англи, Монгол хоёр хэлээр тухайн нисгэгчийн хувийн мэдээлэл, нисгэгчийн ур чадварын түвшин, тусгай чадварыг олон улсад хэвшсэн байдлаар үсэг, тоо хослуулан тэмдэглэсэн байна.

ДӨРӨВ. БУСАД

4.1 Нисгэгчийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэх, дамжуулж хэрэглэхийг хориглоно, ийм үйлдэл гаргасан тохиолдолд нисгэгчийн үнэмлэхийг хүчингүй болгож, хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

4.2 Нисгэгчийн үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд харьяалсан клуб болон МПХ-д мэдэгдээд, шинэчлэн авах өргөдлөө клубээрээ дамжуулан МПХ-д ирүүлнэ.

4.3 Үнэмлэх олгох, шинэчлэн олгохтой холбоотой зардлыг өргөдөл гаргагч төлнө.

МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБООНЫ ПАРАГЛАЙДЕРЫН НИСГЭГЧИЙН ТҮВШИН ТОГТООХ ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМ (ТТҮС)

Зорилго:

Параглайдерын нисгэгчийн түвшин тогтоох үнэлгээний систем (ТТҮС) нь параглайдингийн спортоор хичээллэж буй суралцагч, нисгэгч, тамирчдын мэдлэг, туршлага, ур чадварын бодит түвшинг тогтоон, тэдэнд нисгэгчийн үнэмлэх (National pilot license) олгоход оршино.

Ерөнхий зүйл:

Энэхүү үнэлгээний системийг FAI-н SafePro Para буюу "Параглайдингийн аюулгүй ажиллагаа, сургалтын хөтөлбөр"-т үндэслэн, Параглайдингийн спорт хөгжиж төлөвшсөн бусад орнуудын ижил төстэй системүүдийг харьцуулан, манай улсад уг спорт хөгжиж буй өнөөгийн төлөв, чиг хандлага, нисгэгчдийн ур чадвар, төлөвшлийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр боловсруулав.

МПХ -нь энэхүү 5-н шатлалт түвшин тогтоох үнэлгээний системийг боловсруулахдаа шат тус бүрээр нисгэгчдийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, туршлага, ур чадварыг нарийвчлан тодорхойлж, хэмжиж болохуйц байдлаар оруулсан болно.

Энэхүү үнэлгээний системийн дагуу үнэлэгдэн Р3- түвшин тодорхойлогдсон нисгэгчид FAI-н IPPI карт авах эрх үүснэ. Хүсэлт гаргагч нь IPPI картын төлбөрийг хариуцна.

Гадаад улсад нисэхэд FAI-н IPPI карт нь Үндэсний нисгэгчийн үнэмлэхийн хамт хүчинтэй байна.

(Р1) Эхлэн суралцагч

1. Ерөнхий шаардлага – Эхлэн суралцагч нь инструкторын шууд удирдлага дор, тогтоосон хязгаарлалтын хүрээнд нислэг үйлдэн, дадлага хийж, үндсэн мэдлэг, ур чадваруудыг эзэмшсэн байна. Мөн энэхүү МПХ-ний ТТҮС болон зөвлөмж болгож буй хязгаарлалтуудын талаар ойлголттой байна.
2. Эхлэн суралцагч нь дараах даалгаруудыг биелүүлэн, биеэр үзүүлэх чадвартай байна. Үүнд:
   2.1 Газрын бэлтгэлийн үндсэн хичээлийг дүүргэх
   2.2 Далавч, суудлаа дэлгэх, холбох, нислэгийн өмнөх үзлэг хийх
   2.3 Гараа хийхийн өмнө далавчаа удирдах, хяналтад байлгах
   2.4 Далавч босгохоос өмнө суудал зөв бэхлэгдсэн эсэх, строп болон жолоо орооцолдсон эсэхийг шалгаж, засах
3. Бие даан гараа үйлдэх. Ингэхдээ:
   3.1 Далавчаа зөөлөн, итгэлтэй босгох, гүйх
   3.2 Гараа үйлдэх үедээ далавчаа хянах
   3.3 Чиглэлээ хянах
   3.4 Гүйлтээс нислэг рүү зөөлөн шилжих
4. Агаар дахь хурдаа мэдэрч, хянах. Ингэхдээ:

4.1 Агаар дахь тогтмол хурд
4.2 Урьдчилан сонгосон газардах талбайг чиглэсэн жигд, шулуун нислэг
4.3 Далавч хянах, удирдах мэдлэгээ харуулахын сацуу агаар дахь хурдаа итгэлтэйгээр, бага зэрэг өөрчлөх
4.4 Удирдлагын хяналтаа алдахгүйгээр агаар дахь хурдаа зөөлөн ихэсгэж, багасгах
4.5 Хөл дээрээ, салхины эсрэг аюулгүй, зөөлөн газардах чадваруудаа харуулахуйц 2 нислэг тус тус үйлдсэн байна.

5. Тухайн нислэгийн байршил дээр:
   5.1 Салхины чиглэл
   5.2 Салхины хурд
   5.3 Газар нутгийн хэлбэр
   5.4 Бартаа саад нислэгт нь хэрхэн нөлөөлж болохыг таньж, ойлгох чадвартай байх
6. Нислэг бүртээ газардсаны дараах үйлдлүүдийг зөв дарааллаар хийж сурсан байх:
   6.1 Далавчаа унтраах
   6.2 Далавчаа идэвхгүй болгох
   6.3 Нислэгийн хөдөлгөөнийг анхаарах
   6.4 Газардах талбайгаас далавчаа холдуулах
   6.5 Далавчаа биеэсээ салгах
7. Далавч хэрэгслээ зөв эвхэх, хадгалах, арчлах тухай ойлголттой байх
8. Тухайн шатандаа тохирсон мэдлэг, мэдээлэл, нөхцөл байдлыг зөв үнэлэх, дүгнэх чадвартай байх
9. Анхан шатны бичгийн шалгалтад тэнцсэн байх
10. Эхлэн суралцагчид тавих хязгаарлалтууд:
    10.1 Зөвхөн дээр дурдсан анхан шатны бүх чадварыг бүрэн эзэмшсэний дараа, мөн үүсэж болзошгүй асуудал, аюултай нөхцөл байдлыг бүрэн ойлгож ухамсарласны дараа энэ хязгаарлалтуудыг давах ёстой.
    10.2 Бүх нислэг зөвхөн МПХ-ний инструкторын шууд удирдлага доор хийгдэнэ.
    10.3 Зөвхөн 3 м/с болон түүнээс бага хурдтай, жигд салхитай үед нислэг үйлдэнэ.
    10.4 Зөвхөн 3:1-4:1 (18^0 – 14^0) налуутай хяраас, хөл дээрээс гараа үйлдэнэ.
    10.5 Төлөвлөсөн нислэгийн зам аль ч тал руугаа 60^0-ын дотор ямар ч бартаа саадгүй, нисгэгч гарааны шугамаас газардах талбай хүртэл маневр хийлгүй шулуун нисэж, газардах талбайг өнгөрч нисэхээргүй нөхцөл бүрдсэн үед л гараа үйлдэнэ.
    10.6 Зөвхөн өөрийн ур чадварын түвшинд тохирсон байршилд нислэг үйлдэнэ.
    10.7 Зөвхөн суралцагч болон шинэ нисгэгчид тохирно гэж үйлдвэрлэгчээс зөвлөсөн А ангилалын далавчаар нислэг үйлдэнэ.

(P2) Шинэ нисгэгч

1. Ерөнхий шаардлага – Шинэ нисгэгч нь инструкторын шууд удирдлага дор, тогтоосон хязгаарлалтын хүрээнд нислэг үйлдэх дадлага хийж, үндсэн мэдлэг, ур чадваруудыг эзэмшсэн байна. Мөн энэхүү МПХ-ний ТТҮС болон зөвлөмж болгож буй хязгаарлалтуудын талаар ойлголттой байна. Анхан шатанд эзэмшсэн байвал зохих бүх мэдлэг, ур чадваруудыг хангалттай харуулахын сацуу бүх нислэгээ урьдчилан төлөвлөж, инструктортойгоо ярилцан, зөвшөөрөл авсан байна.
2. Шинэ нисгэгч дараах даалгаруудыг биелүүлэн, биеэр үзүүлэх чадвартай байна. Үүнд:

2.1 Бүртгэл (log) хөтлөх. Ингэхдээ:

2.1.1 Хамгийн багадаа 8 цагийн онолын хичээлд суусан байх (цаг агаар, гараа, аюултай шинж тэмдгүүд, газардалт, суулт (approach), тоног төхөөрөмжүүд, нислэгийн байршил тус бүрийн онцлог г.м)

2.1.2 Хамгийн багадаа 35 удаа нислэг үйлдсэн байх (зөв суулт, газардалт хийх техникийг бүрэн эзэмшсэнээ харуулах)

2.1.3 Хамгийн багадаа 7 өдөр нислэг үйлдсэн байх

2.2 Биеэр үзүүлэх ёстой мэдлэг, ур чадварууд:

2.2.1 Далавч, суудал, нөөц шүхрийг дэлгэх, нислэгийн өмнөх үзлэг хийх

2.2.2 Тухайн байршлын ерөнхий нөхцөл байдал, нислэгийн төлөвлөгөө, зам, салхины урсгалын хувьд зайлсхийх ёстой хэсгүүд, мөн зай барих ёстой бартаа саадын талаар найдвартай дүн шинжилгээ хийж чаддаг байх

2.2.3 5 удаа дараалан урагш (forward) гараа үйлдэхээр далавчаа босгох, ингэхдээ далавчаа харж шалгах техник

2.2.4 5 удаа дараалан эргэх (reverse) гараа үйлдэхээр далавчаа босгох, зөв унтраах техник

2.2.5 Жигд салхинд 2 минутын турш далавчаа дээрээ тогтоож, удирдах техник

3. Далавч босгохоос өмнө суудал зөв бэхлэгдсэн эсэх, строп болон жолоо орооцолдсон эсэхийг шалгаж, засах арга барилыг нислэг бүрд үзүүлэх.

4. Агаар дахь хурдаа бага зэрэг өөрчлөх, чиглэлээ өөрчлөхгүйгээр хамгийн бага хэмжээнд шумбах техник

5. Нислэгийн үед өндөр алдуулахын тулд далавчаа аюулгүй бөгөөд маш бага хэмжээгээр хааж, (Ингэхдээ далавчийг унтрах хэмжээнд хүртэл ХЭЗЭЭ Ч ХААХГҮЙ) дараа нь чиглэлээ өөрчлөхгүйгээр агаар дахь хэвийн хурд руу зөөлөн шилжих техникийг харуулах

6. Төлөвлөсөн замын дагуу, чиглэлээ 90^0 -аар өөрчлөх “S” эргэлтүүд хийн нислэг үйлдэх. Ингэхдээ салхины эсрэг нисэж байгаад чиглэлээ 45^0-с бага эргэж өөрчлөхгүй. Эргэлтүүд зөөлөн, агаар дахь хурдыг тооцсон байхаас гадна шулуун чиглэлд хөл дээр, аюулгүй газардах боломжтой байх.

7. Далавчны давших хурд, давшилтын өнцөг өөр өөр байх үед хоёр тал руугаа 180^0 эргэлт хийх техник.

8. 360^0 эргэлтийг яаж аюулгүй гүйцэтгэх, эрсдэлийн хүчин зүйлс болон шийдвэр гаргах үйл явцыг тайлбарлаж чаддаг байх

9. Гараар жолоодолгүй нислэг үйлдэх, нэг гараар жолоодох, биеийн жинг шилжүүлэн эргэлт үйлдэх, хойд riser-аар удирдан эргэлт хийх техник

10. Далавчны үзүүрийг тэгш хэмт болон тэгш хэмт бус хааж, доошлох хурдыг нэмэх (чих тавих)

11. Уулын хяр болон салхины хүчтэй урсгал өдөөгч бусад зүйлсийг зөв үнэлж, зохистой зай барих

12. Урьдчилан товлосон газардах зурвас буюу тойрогт 5 удаа дараалан аюулгүй, зөөлөн, салхины эсрэг, хөл дээрээ газардах. Газардах талбай гараанаас холгүй байснаар цэгээс давж нисэхгүйн тулд тохирсон эргэлтүүд үйлдэн зөв суулт хийх боломжтой байна.

13. Хүчтэй салхинд хэрхэн зөв газардах, яавал хойшоо чирэгдэхгүй байхыг тайлбарлаж чаддаг байх
14. Далавчаа хэрхэн зөв арчлах талаар мэдлэгтэй байх
15. Нислэгийн замаа хэрхэн уртасгах, богиносгох боломжтойг тайлбарлах
16. Баруун гарын дүрмийг тайлбарлах
17. Speed bar/хурдасгуурын системийг зөв ашиглаж харуулах
18. Агаарын урсгалын сэгсрэлт, далавчны үйл ажиллагааны доголдлыг дүрсэлсэн симуляцийн орчинд суудалдаа бэхлэгдсэн байрлалаас нөөц шүхрээ задлах
19. Дараах тохиолдолд юу хийх ёстойг тайлбарлаж чаддаг байх. Үүнд:
    - 19.1 Далавч нэг талаасаа 25% нурсан тохиолдолд чиглэлээ хянахын зэрэгцээ нуралтыг хэрхэн засах
    - 19.2 Өргөлт, өндөр алдалт, эргэлтийн үед далавч санаандгүй унтрах, эргэлдэх ямар ч нөхцөл үүсгэлгүй хамгийн бага хэмжээний өндөр алдалттай нисэх
    - 19.3 Өндөр алдалтын болон давших хурдыг ихэсгэх
    - 19.4 Шүхрээр зөв газардах (PLF-Parachute landing fall) техникийг харуулах
    - 19.5 Шинэ нисгэгчийн бичгийн шалгалтад тэнцсэн байх
20. Шинэ нисгэгчид тавих хязгаарлалтууд:
    - 20.1 Зөвхөн дээр дурдсан шинэ нисгэгчийн бүх чадварыг бүрэн эзэмшсэний дараа, мөн үүсэж болзошгүй асуудал, аюултай нөхцөл байдлыг бүрэн ойлгож ухамсарласны дараа энэ хязгаарлалтуудыг давах ёстой.
    - 20.2 Үндсэн салхины дээд хурд 4.5 м/с
    - 20.3 Огцом салхины дээд хурд 6.7 м/с
    - 20.4 Огцом салхины давтамж дээд тал нь 5 секундэд 2.2 м/с
    - 20.5 Өргөлтийн хурд секундэд 1 м-с дээш байх нөхцөлд термалдах нислэг хийхгүй.
    - 20.6 Хөл дээрээс гараа үйлдэхдээ зөвхөн 4:1 (14^0) –с илүү налуутай хяраас, салхи хяр өөд 25^0-ын өнцөг дотор үлээж байхад гарна.
    - 20.7 1.3 м/с-с дээш хурдтай салхинд татлагатай гараа үйлдэхдээ салхи зөвхөн чирэлтийн шугам дагуу 25^0-ын өнцөг дотор байхад үйлдэнэ.
    - 20.8 Газардах талбай харагдахуйц байрлалаас гараа үйлдэнэ.
    - 20.9 Аль ч талын жолоог 2/3-с хэтрүүлэн татахаас зайлсхийх
    - 20.10 Эргэлтийг 30^0-аас хэтрүүлэхгүй, эргэлтийн хурдыг шулуун нислэгийн хурдаас 1.5 дахин бага байхаар хязгаарлах, хэт огцом болон хурдтай болж буй спираль эргэлтээс зөөлөн гарах
    - 20.11 Зөвхөн анхан шатны нисгэгчдэд тохирно гэж үйлдвэрлэгчээс зөвлөсөн А ангилалтын далавчаар ниснэ.

(Р3) Дунд шатны нисгэгч

1. Ерөнхий шаардлага – Дунд шатны нисгэгч нь зөөлөн болон аядуу нөхцөлд, ихэнх байршлуудад халих нислэг хийж чадах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байхаас гадна өөрийнх нь мэдлэг, ур чадвар, туршлагын түвшинд тухайн байршил болоод нөхцөл байдал тохирох эсэхийг үнэлэх чадвартай байна. Мөн энэхүү МПХ-ний ТТҮС болон зөвлөмж болгож буй хязгаарлалтууд, хярд халих, термалд нисэх энгийн ойлголтууд, баруун гарын дүрэм, зохицуулалттай агаарын орон зайд нислэг үйлдэхгүй байх талаар ойлголт авсан байна.

2. Дунд шатны нисгэгч дараах даалгаруудыг биелүүлэн, биеэр үзүүлэх чадвартай байна. Үүнд:

   2.1 Бүртгэл (log) хөтлөх. Ингэхдээ:

   - 2.1.1 30-аас дээш өдөр нислэг үйлдсэн байх
   - 2.1.2 90-дээш удаа нислэг үйлдсэн байх
   - 2.1.3 20-оос дээш цагийн соло нислэг үйлдсэн байх

   2.2 Биеэр үзүүлэх ёстой мэдлэг, ур чадварууд:

   - 2.2.1 Баруун гарын дүрэм, ИНЕГ-ын холбогдох дүрмүүд, агаар дахь хурдаа хянах, далавч унтрах, эргэлдэх, агаарын сэгсрэлтээс үүссэн нуралт ба түүнийг засах талаар мэдлэгтэй байх
   - 2.2.2 Салхины сүүдэр (хуйлралт), gradients, өргөлт, sink, тогтмол урсгал, сэгсрэлт ба хуй салхи болон төлөвлөсөн нислэгийн зам, эргэлтүүдэд тэдгээрийн үзүүлэх нөлөөг тайлбарлаж чаддаг байх
   - 2.2.3 Ажиглаж буй нислэг бүрийнхээ төлөвлөгөөг дүрслэн хэлж чаддаг байх
   - 2.2.4 Нислэг бүрийн өмнө суудал, далавч, нөөц шүхрийн нарийвчилсан үзлэг хийдэг байх
   - 2.2.5 Далавч босгохоос өмнө суудал зөв бэхлэгдсэн эсэх, строп болон жолоо орооцолдсон эсэхийг шалгаж, засах арга барилыг нислэг бүрд үзүүлэх
   - 2.2.6 Далавч асаах, гараа үйлдэх бүрд хяналтыг гартаа авч, өөртөө итгэлтэй, гүйлтээс нислэг рүү аажмаар шилжих
   - 2.2.7 Газардалт бүр аюулгүй, зөөлөн, хөл дээр, хяналттай байх
   - 2.2.8 Агаар дахь хурд ба газрын хурд хоёрын ялгааг мэддэг байх
   - 2.2.9 Урьдчилан тодорхойлсон замын дагуу 180^0 эргэлтүүдийг хийхдээ хяналттай, зөөлөн бөгөөд янз бүрийн хурд, эргэлтийн өнцөгтэй үед зохицуулан хийх
   - 2.2.10 Янз бүрийн хурд, эргэлтийн өнцөгтэй үед хоёр тал руугаа 360^0 эргэлт хийж чаддаг байх
   - 2.2.11 Тэгш хэмтэй болон тэгш бус хэмтэй чих тавих (нэг талдаа 25% буюу нийт 50%), эсвэл хурдан доошлохын тулд далавчны талбайг багасгах өөр аргыг үзүүлэх
   - 2.2.12 Давших хурдыг ихэсгэх нэг аргыг харуулах
   - 2.2.13 Зөв цагт зохистой хэмжээнд тоормос хэрэглэх замаар огцом өргөлтийг хянах чадварыг харуулах
   - 2.2.14 Далавч нэг талаасаа 50% нурах тохиолдолд чиглэлээ хадгалсан хэвээр далавчаа хэрхэн сэргээх дарааллыг дүрслэн хэлж чаддаг байх
   - 2.2.15 Яагаад газардахаас бусад тохиолдолд буюу нислэгийн үед далавчийг их хэмжээгээр хаалттай нисэн болохгүйг, мөн далавч (нэг ба хоёр тал) унтрах

хэмжээнд орсон үед ямар шинж тэмдэг ажиглагдахыг дэлгэрэнгүй тайлбарлаж чаддаг байх

2.2.16 Салхины хурд 3.5-6.7 м/с байхад хажуугаас болон өмнөөс салхитай үед агаар дахь хурдаа хамгийн бага шумбалттай байхаар тохируулж, далавч унтраах ямар ч эрсдэлгүйгээр нислэг үйлдэж чадах

2.2.17 Эргэлт, суулт хийх шаардлагатай нислэгийн дараа газардах талбайн 10%-ийн дотор 5 удаа газардах нислэг үзүүлэх

2.2.18 Газардахаар суулт хийх үед gradient-аар доошлохдоо агаар дахь хурдаа зөв тохируулах

2.2.19 Өөдөөс салхины хүч нэлээд ихтэй үед туулсан замын хугацаанд зохистой агаар дахь хурд үзүүлэх

2.2.20 Татлагатай гарааны зарчмыг бүрэн ойлгосон байх

2.2.21 Дунд шатны нисгэгчийн бичгийн шалгалтад тэнцсэн байх

3. **Дунд шатны нисгэгчид тавигдах хязгаарлалтууд:**

3.1 Үндсэн салхины дээд хурд 6.7 м/с

3.2 Огцом салхины дээд хурд 8 м/с

3.3 Огцом салхины давтамж дээд тал нь 5 секундэд 2.2 м/с

3.4 Газарт ойртсон үед огцом эргэлт хийхгүй

3.5 Аль ч талын тоормосыг 3/4-с хэтрүүлэн татахаас зайлсхийх

3.6 Эргэлтийн өнцгийг үйлдвэрлэгчийн зөвлөснөөс хэтрүүлэхгүй хэмжээнд барих, эргэлт хийх үеийн хурдыг шулуун нислэгийнхээс 2 дахин багасгах, хэт огцом болон хурдтай болж буй спираль эргэлтээс зөөлөн гарах

3.7 Салхины хурд 6.7 м/с-с дээш байх үед уул, толгой, хяраас гадагшаа чиглэлд 300^0 ямар ч саадгүй тохиолдолд, 4.4 м/с-с дээш үед 200^0 саадгүй байхад л салхины уруу эргэлт хийж болно.

3.8 2.5 м/с-с илүү өргөлттэй термалд болон босоо үүл их хэмжээгээр үүссэн тохиолдолд нисэхгүй.

(P4) Ахисан шатны нисгэгч

1. Ерөнхий шаардлага – Ахисан шатны нисгэгч нь халих нислэгийн нэлээд хүнд нөхцөлд, техник ур чадвар шаардахуйц байршлуудад нислэг хийж чадах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байхаас гадна өөрийнх нь мэдлэг, ур чадвар, туршлагын түвшинд тухайн байршил болоод нөхцөл байдал тохирох эсэхийг үнэлэх чадвартай байна. Мөн энэхүү МПХ-ний ТТҮС болон зөвлөмж болгож буй хязгаарлалтууд, чөлөөт нислэгт хамааралтай бүх дүрэм журмын талаар ойлголт авсан байна.
2. Ахисан түвшинд байвал зохих аливааг үнэлж цэгнэх чадвар, төлөвшил олсон байна.
3. Ахисан шатны нисгэгч дараах даалгавруудыг биелүүлэн, биеэр үзүүлэх чадвартай байна. Үүнд:

3.1 **Бүртгэл (log) хөтлөх. Ингэхдээ:**

3.1.1 250 удаагийн нислэг

3.1.2 Дунд шатанд тохирсон нөхцөлд, 5 өөр байршилд, тус бүр 5 нислэг үйлдсэн байх

3.1.3 80 өдрөөс дээш нислэг үйлдсэн байх

3.1.4 Термалтай орчинд 3 аас дээш удаа 1 цагаас багагүй хугацаатай нислэг үйлдсэн байх. Үүнд хярын салхинд халих нислэгийг тооцохгүй. Эдгээр нислэг нь дунд шатны нөхцөлд, дор хаяж 2 өөр газраас гараа хийсэн нислэг байна.

3.1.5 1 цагаас дээш хугацаатай хярд халих нислэг үйлдсэн байх. Үүнд термалд өргөгдсөн нислэг тооцогдохгүй.

3.1.6 Нийт нислэгийн цаг 75 цагаас дээш, үүнээс тандем нислэг 25-с ихгүй, термалтай орчинд ниссэн нислэг 25 байх ёстой бөгөөд 10 нь тандем байж болно.

3.1.7 5 өөр далавчаар нислэг үйлдсэн байх.

4. **Биеэр үзүүлэх ёстой мэдлэг, ур чадварууд:**

4.1 Нислэг бүрийн өмнө суудал, далавч, нөөц шүхрийн нарийвчилсан үзлэг хийдэг байх

4.2 Нислэгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх

4.3 Нислэгийн төлөвлөгөө гаргах

4.4 Далавч босгохоос өмнө суудал зөв бэхлэгдсэн эсэх, строп болон жолоо орооцолдсон эсэхийг шалгаж, засах арга барилыг нислэг бүрд үзүүлэх

4.5 Далавч асаах, гараа үйлдэх бүрд зоримог, өөртөө итгэлтэй үйлдэл үзүүлж, гүйлтээс нислэг рүү аажмаар шилжих. Далавч асаах, гараа хийхдээ үйлдэл удаан, тогтворгүй байвал хангалттай гэж үзэхгүй

4.6 Газардалт бүр аюулгүй, зөөлөн, хөл дээр, хяналттай байна

4.7 360^0-ын эргэлтүүд үйлдэхдээ “8-ын тоо” нислэгийн ур чадвар харуулах, ингэхдээ агаар дахь хурд, эргэлтийн өнцөг болон хурдаа зөв тохируулж, дараалан 2 удаа “8-ын тоо”-г цэвэрхэн хийж үйлдэх

4.8 Дараалан 3 удаа газардах зурвасын 10% дотор газардах, ингэхдээ суултын үед эргэлт хийхээр нөхцөлтэй байна. Буултын нөхцөл тааламжтай байх үед нислэг бүрд газардах цэгийг бага зэрэг өөрчилж байрлуулж болно. Дор хаяж нэг минутын, газраас дээш өндөр (AGL) 200’ байхаар нислэгүүд байна.

4.9 Чиглэлээ хянасан хэвээр далавчийг нэлээд их хэмжээнд (50%) тэгш хэмтэй бус нурааж, сэргээх

4.10 Татлагатай гарааны тухай бүрэн ойлголттой, ярилцах хэмжээнд байх

4.11 Ахисан шатны нисгэгчийн бичгийн шалгалтад тэнцсэн байх

4.12 Гарааны болон нислэгийн ур чадвар нэлээд шаардахуйц байршилд, өөртөө болон бусдад аюул учруулахгүйгээр нисэж чадна гэсэн итгэл төрүүлэхүйц байх

4.13 МПХ-г үүргээс чөлөөлсөн тухай баримт бичгийн заалтуудыг хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурсан байх, эх хувийг МПХ-д хадгалуулах

4.14 Ахисан шатны нисгэгчид зөвлөмж болгох Үйл ажиллагааны хязгаарлалтууд:

4.15 Зөөлөн салхитай нөхцөлд өөр далавчнаас 30’-ын дотор нисэхгүй, агаарын урсгалын бага зэрэг сэгсрэлттэй орчинд өөр далавчнаас 100’-ын дотор нисэхгүй байх.

(P5) Мастер нисгэгч

1. Ерөнхий шаардлага – Параглайдингийн спортоор хичээллэж, ур чадвараа цааш нь ахиулах хүсэлтэй нисгэгчдийн хувьд ахисан шатны дараагийн буюу мэргэжлийн түвшний ур чадварыг эзэмшин, Мастер нисгэгч болох боломжтой. Харин Мастер нисгэгчийн түвшинд тохирох нислэгийн байршлыг тусгайлан заахгүй. Мастер нисгэгч нь энэ түвшинд байвал зохих аливааг үнэлж цэгнэх чадвар, өндөр хэмжээний төлөвшил олсон байна.

2. Мастер нисгэгч дараах даалгавруудыг биелүүлэн, биеэр үзүүлэх чадвартай байна. Үүнд:

   2.1 Бүртгэл (log) хөтлөх. Ингэхдээ:

   2.1.1 Бүх тусгай ур чадваруудыг эзэмшсэн байх

   2.1.2 Доорх хүснэгтийн 6-с доошгүй категориор 1,450-с доошгүй оноо авсан байх. Нислэгийн цаг 400 цагаас дээш байхаас 200-с багагүй нь термалд ниссэн байх, хамгийн багадаа 500 нислэг бүртгэгдсэн байх.

   2.1.3 МПХ-ний инструкторын зөвлөлөөс тодорхойлолт авсан байх, тэдгээр нь нислэгийн ур чадварыг гэрчлэхээс гадна ялангуяа нисгэгчийн аливааг үнэлж цэгнэх чадвар, төлөвшлийн талаар тусгасан байх.

   2.1.4 Ямар ч аюул осолгүй дараалсан 100 болон түүнээс дээш нислэг үйлдсэн байх

Үнэлгээний категори	**Оноо**	**Зөвшөөрөгдөх дээд оноо**
Нислэгийн цаг (минимум 400)	400-аас давсан цаг бүрт 1 оноо	350
Нислэгийн тоо (минимум 500)	500-аас давсан нислэг бүрт 1 оноо	250
Өндөр авалт (1 нислэгт 1 тооцогдох)	2000’ – 10 оноо 3000’ – 15 оноо 4000’ – 20 оноо 5000’ – 25 оноо 6000’ – 30 оноо	350
Кросскантри нислэг (дор хаяж 16 км)	1 нислэгт 1 оноо	350
Нислэгийн байршлын тоо	1 байршилд 10 оноо	300
Далавчны тоо	1 далавч 5 оноо	150
Тэмцээнд оролцсон байдал	1-р байр 50 оноо 2-р байр 40 оноо 3-р байр 30 оноо 4-р байр 20 оноо 5-р байр 10 оноо	100
Тандем нислэг	1 нислэгт 10 оноо	100
Татлагатай гараа	1 нислэгт 5 оноо	100

Тусгай ур чадварууд:

1. **P2-P5 түвшинд:**
   1.1 Хөл дээрээс гараа үйлдэх (FL)
   1.2 Хярын салхинд халин нисэх (RS)
   1.3 Салхи багатай үед эгц хяраас, эсвэл тусгай зассан тавцангаас гараа хийх чадвар (CL)
   1.4 Тэгш хяраас гараа хийх (FSL)
   1.5 Хязгаарлагдмал талбайд газардах (RLF)
   1.6 Агаарын урсгалын сэгсрэлттэй орчинд нисэх (TUR)
   1.7 Хэт өндрөөс гараа хийх (HA)
   1.8 Татлагатай гараа хийх (ST)
   1.9 Пара-цана (PS)
2. **P3-P5 түвшинд:**
   2.1 Кросскантри (XC)
   2.2 Мини-винг (M1 ба M2)

Журам баталсан

МПХ Удирдах зөвлөлийн гишүүд:

А.Батдаваа

Н.Мөнхбаяр

С.Очхүү

П.Бэхболд

Ц.Мягмардорж

Б.Болормаа

П.Болд

Б.Дарамжав

Г.Мөнхсайхан

Р1- ЭХЛЭН СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Овог, нэр: _____ Клуб: _____
Багш:_____

А. Онолын мэдлэг (Минимум 8 цагийн онолын хичээлд суусан байна)

Сэдэв	Цаг	Эзэмшсэн эсэх	Багшийн гарын үсэг
Аэродинамикийн суурь мэдлэг			
Нислэгийн цаг агаарын суурь мэдлэг			
Нислэгийн төхөөрөмж, хэрэгсэл			
Нислэгийн техникүүд, нэр томьёо			
Эхлэн суралцагчид тавигдах хязгаарлалтууд			
Аюулгүй ажиллагааны үндсэн мэдлэг			

Онолын шалгалт авсан: он, сар, өдөр _____ Оноо: _____

Шалгагч багш (нар):

_____

Б. Биеэр үзүүлэх ур чадвар:

Даалгавар	+	-	Багшийн гарын үсэг
1.Далавч, суудлаа дэлгэх, холбох, нислэгийн өмнөх үзлэг хийх			
2. Гараа хийхийн өмнө далавчаа удирдах, хяналтад байлгах			
3. Далавч босгохоос өмнө суудал зөв бэхлэгдсэн эсэх, строп болон жолоо орооцолдсон эсэхийг шалгаж, засах			
4. Бие даан гараа үйлдэх. Ингэхдээ:			
а. Далавчаа зөөлөн, итгэлтэй босгох, гүйх			
б. Гараа үйлдэх үедээ далавчаа хянах			
в. Гүйлтээс нислэг рүү зөөлөн шилжих			
5. Агаар дахь хурдаа мэдэрч, хянах. Ингэхдээ дараах чадваруудаа харуулахуйц 6 нислэг үйлдсэн байна. Үүнд:			
а. Агаар дахь тогтмол хурд			
б. Урьдчилан сонгосон газардах талбайг чиглэсэн жигд, шулуун нислэг			
в. Далавч хянах, удирдах мэдлэгээ харуулахын сацуу агаар дахь хурд ба чиглэлээ итгэлтэйгээр, бага зэрэг өөрчлөх			
г. Удирдлагын хяналтаа алдахгүйгээр агаар дахь хурдаа зөөлөн ихэсгэж, багасгах			
д. Хөл дээрээ, салхины эсрэг аюулгүй, зөөлөн газардах			

6. Тухайн нислэгийн байршил дахь дараах зүйлс нислэгт нь хэрхэн нөлөөлж болохыг таньж, ойлгох чадвар			
а. салхины чиглэл			
б. салхины хурд			
в. газар нутгийн хэлбэр			
г. бартаа саад			
7. Нислэг бүртээ газардсаны дараах үйлдлүүдийг зөв дарааллаар хийж сурсан байх			

Суралцагч _____Р1 түвшний мэдлэг, ур чадваруудыг эзэмшсэн болно.

Сургагч багшийн нэр: _____ Гарын үсэг_____

Он, сар, өдөр _____

P2- ШИНЭ НИСГЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Овог, нэр: _____ МПХ үнэмлэх #_____

Клуб: _____

Багш:_____

А. Онолын мэдлэг (Минимум 8 цагийн онолын хичээлд суусан байна)

Сэдэв	Цаг	Эзэмшсэн эсэх	Багшийн гарын үсэг
Аэродинамик			
Нислэгийн цаг агаар			
Нислэгийн орчин, байршлын онцлог			
Аюултай шинж тэмдгүүд			
Аюулгүй ажиллагааны журам			
Ослын үеийн ажиллагаа			
Агаарын зайн дүрэм, журмууд			

Онолын шалгалт авсан: он, сар, өдөр _____ Оноо: _____

Шалгагч багш (нар):

_____

Б. Нислэгийн бүртгэл (log): Минимум 35 нислэг, 7 өдөр бүртгэж, багшийн гарын үсгээр баталгаажсан байна.

В. Биеэр үзүүлэх ур чадвар:

Даалгавар	+	-	Багшийн гарын үсэг
1.Далавч, суудал, нөөц шүхрийг дэлгэх, нислэгийн өмнөх үзлэг хийх			
2.Урагш гараа үйлдэхээр далавчаа босгох, ингэхдээ далавчаа харж шалгах техник			
3.Эргэх гараа үйлдэхээр далавчаа босгох, зөв унтраах техник			
4.Жигд салхинд 2 минутын турш далавчаа дээрээ тогтоож, удирдах техник			
5.Далавч босгохоос өмнө суудал зөв бэхлэгдсэн эсэх, строп болон жолоо орооцолдсон эсэхийг шалгаж, засах арга барилыг нислэг бүрд үзүүлэх			
6.Агаар дахь хурдаа бага зэрэг өөрчлөх, чиглэлээ өөрчлөхгүйгээр хамгийн бага хэмжээнд шумбах техник			
7.Хамгийн бага хэмжээнд шумбахдаа далавчаа аюулгүй бөгөөд маш бага хэмжээгээр хаах, дараа нь чиглэлээ өөрчлөхгүйгээр агаар дахь хэвийн хурд руу зөөлөн шилжих техникийг харуулах. Ингэхдээ далавчийг унтрах хэмжээнд хүртэл ХЭЗЭЭ Ч ХААХГҮЙ.			
8.Төлөвлөсөн замын дагуу, чиглэлээ 90º -аар өөрчлөх “S” эргэлтүүд хийн нислэг үйлдэх			

9.Далавчны давших хурд, давшилтын өнцөг өөр өөр байх үед хоёр тал руугаа 180^0 эргэлт хийх техник			
10.Гараар жолоодолгүй нислэг үйлдэх, нэг гараар жолоодох, биеийн жинг шилжүүлэн эргэлт үйлдэх, хойд жолоогоор удирдан эргэлт хийх техник			
11.Чих тавьж хурдан доошлох техник			
12.Уулын хяр болон салхины хүчтэй урсгал өдөөгч бусад зүйлсийг зөв үнэлж, зохистой зай барих, холдох техник			
13.Урьдчилан товлосон газардах зурвас буюу тойрогт 5 удаа дараалан аюулгүй, зөөлөн, салхины эсрэг, хөл дээрээ газардах			
14.Хүчтэй салхинд хэрхэн зөв газардах, яавал хойшоо чирэгдэхгүй байхыг тайлбарлаж чаддаг байх			
15.Нислэгийн замаа хэрхэн уртасгах, богиносгох боломжтойг тайлбарлах			
16.Баруун гарын дүрмийг тайлбарлах			
17.Speed bar/хурдасгуурын системийг зөв ашиглаж харуулах			
18.Симуляцийн орчинд суудалдаа бэхлэгдсэн байрлалаас нөөц шүхрээ задлах			

Нисгэгч _____P2 түвшний мэдлэг, ур чадваруудыг эзэмшсэн болно.

Сургагч багшийн нэр: _____ Гарын үсэг_____

Он, сар, өдөр _____

Р3 - ДУНД ШАТНЫ НИСГЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Овог, нэр: _____ МПХ үнэмлэх #_____

Клуб: _____

Багш:_____

А. Онолын мэдлэг (Минимум 8 цагийн онолын хичээлд суусан байна)

Сэдэв	Цаг	Эзэмшсэн эсэх	Багшийн гарын үсэг
Баруун гарын дүрэм, ИНЕГ-ын холбогдох дүрмүүд			
Агаар дахь хурдаа хянах, далавч унтрах, эргэлдэх, агаарын сэгсрэлтээс үүссэн нуралт ба түүнийг засах			
Салхины сүүдэр (хуйлралт), gradients, өргөлт, sink, тогтмол урсгал, сэгсрэлт ба хуй салхи болон төлөвлөсөн нислэгийн зам, эргэлтүүдэд тэдгээрийн үзүүлэх нөлөө			
Татлагатай гарааны зарчим			
Агаар дахь хурд ба газрын хурд хоёрын ялгаа			

Онолын шалгалт авсан: он, сар, өдөр _____ Оноо: _____

Шалгагч багш (нар):

_____

Б. Нислэгийн бүртгэл (log): Минимум 90 нислэг, 30 өдөр бүртгэж, багшийн гарын үсгээр баталгаажсан байна.

В. Биеэр үзүүлэх ур чадвар:

Даалгавар	+	-	Багшийн гарын үсэг
Урьдчилан тодорхойлсон замын дагуу 180^0 эргэлтүүдийг хийхдээ хяналттай, зөөлөн бөгөөд янз бүрийн хурд, эргэлтийн өнцөгтэй үед зохицуулан хийх			
Янз бүрийн хурд, эргэлтийн өнцөгтэй үед хоёр тал руугаа 360^0 эргэлт хийж чаддаг байх			
Тэгш хэмтэй болон тэгш бус хэмтэй чих тавих (нэг талдаа 25% буюу нийт 50%), эсвэл хурдан доошлохын тулд далавчны талбайг багасгах өөр аргыг үзүүлэх			
Давших хурдыг ихэсгэх нэг аргыг харуулах			
Зөв цагт зохистой хэмжээнд тоормос хэрэглэх замаар огцом өргөлтийг хянах чадварыг харуулах			

Далавч нэг талаасаа 50% нурах тохиолдолд чиглэлээ хадгалсан хэвээр далавчаа хэрхэн сэргээх дарааллыг дүрслэн хэлж чаддаг байх			
Яагаад газардахаас бусад тохиолдолд буюу нислэгийн үед далавчийг их хэмжээгээр хаалттай нисч болохгүйг, мөн далавч (нэг ба хоёр тал) унтрах хэмжээнд орсон үед ямар шинж тэмдэг ажиглагдахыг дэлгэрэнгүй тайлбарлаж чаддаг байх			
Салхины хурд 3.5-6.7 м/с байхад хажуугаас болон өмнөөс салхитай үед агаар дахь хурдаа хамгийн бага шумбалттай байхаар тохируулж, далавч унтраах ямар ч эрсдэлгүйгээр нислэг үйлдэж чадах			
Эргэлт, суулт хийх шаардлагатай нислэгийн дараа газардах талбайн 10%-ийн дотор 5 удаа газардах нислэг үзүүлэх			
Газардахаар суулт хийх үед gradient-аар доошлохдоо агаар дахь хурдаа зөв тохируулах			
Өөдөөс салхины хүч нэлээд ихтэй үед туулсан замын хугацаанд зохистой агаар дахь хурд үзүүлэх			

Нисгэгч _____Р3 түвшний мэдлэг, ур чадваруудыг эзэмшсэн болно.

Сургагч багшийн нэр: _____ Гарын үсэг_____

Он, сар, өдөр _____

Р4- АХИСАН ШАТНЫ НИСГЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Овог, нэр: _____ МПХ үнэмлэх #_____

Клуб: _____

Багш:_____

А. Онолын мэдлэг (Минимум 8 цагийн онолын хичээлд суусан байна)

Сэдэв	Цаг	Эзэмшсэн эсэх	Багшийн гарын үсэг
Нислэгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх			
Нислэгийн төлөвлөгөө гаргах			
Татлагатай гарааны тухай бүрэн ойлголттой, ярилцах хэмжээнд байх			

Онолын шалгалт авсан: он, сар, өдөр _____ Оноо: _____

Шалгагч багш (нар):

_____

Б. Нислэгийн бүртгэл (log): Минимум 250 нислэг, 80 өдөр бүртгэж, багшийн гарын үсгээр баталгаажсан байна. Минимум 5 өөр байршилд, нийт нислэгийн цаг хамгийн багадаа 75 цаг, үүнээс тандем нислэг 25-с ихгүй, термалд ниссэн нислэг 25 цагаас багагүй.

В. Биеэр үзүүлэх ур чадвар:

Даалгавар	+	-	Багшийн гарын үсэг
Далавч асаах, гараа үйлдэх бүрд зоримог, өөртөө итгэлтэй үйлдэл үзүүлж, гүйлтээс нислэг рүү аажмаар шилжих			
Газардалт бүр аюулгүй, зөөлөн, хөл дээр, хяналттай байх			
360^0-ын эргэлтүүд үйлдэхдээ “8-ын тоо” нислэгийн ур чадвар харуулах, ингэхдээ агаар дахь хурд, эргэлтийн өнцөг болон хурдаа зөв тохируулж, дараалан 2 удаа “8-ын тоо”-г цэвэрхэн хийж үйлдэх			
Дараалан 3 удаа газардах зурвасын 10% дотор газардах, ингэхдээ суултын үед эргэлт хийхээр нөхцөлтэй байна.			
Чиглэлээ хянасан хэвээр далавчийг нилээд их хэмжээнд (50%) тэгш хэмтэй бус нурааж, сэргээх			

Нисгэгч _____Р4 түвшний мэдлэг, ур чадваруудыг эзэмшсэн бөгөөд

гарааны болон нислэгийн ур чадвар нэлээд шаардахуйц байршилд, өөртөө болон бусдад аюул учруулахгүйгээр нисэж чадна гэсэн итгэл үнэмшлийг шалгалтын комисст төрүүлсэн болно.

Шалгалтын комисс:

Нэр: _____Гарын үсэг_____ Он, сар, өдөр _____

Нэр: _____Гарын үсэг_____ Он, сар, өдөр _____

Нэр: _____Гарын үсэг_____ Он, сар, өдөр _____

Нэр: _____Гарын үсэг_____ Он, сар, өдөр _____

Нэр: _____Гарын үсэг_____ Он, сар, өдөр _____

P5- МАСТЕР НИСГЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Овог, нэр: _____ МПХ үнэмлэх #_____

Клуб: _____

Багш:_____

Үнэлгээний категори	Оноо	Зөвшөөрөгдөх дээд оноо	Авсан оноо
Нислэгийн цаг (минимум 400)	400-аас давсан цаг бүрт 1 оноо	350	
Нислэгийн тоо (минимум 500)	500-аас давсан нислэг бүрт 1 оноо	250	
Өндөр авалт (1 нислэгт 1 тооцогдох)	2000' – 10 оноо 3000' – 15 оноо 4000' – 20 оноо 5000' – 25 оноо 6000' – 30 оноо	350	
Кросскантри нислэг (дор хаяж 16 км)	1 нислэгт 1 оноо	350	
Нислэгийн байршлын тоо	1 байршилд 10 оноо	300	
Далавчны тоо	1 далавч 5 оноо	150	
Тэмцээнд оролцсон байдал	1-р байр 50 оноо 2-р байр 40 оноо 3-р байр 30 оноо 4-р байр 20 оноо 5-р байр 10 оноо	100	
Тандем нислэг	1 нислэгт 10 оноо	100	
Татлагатай гараа	1 нислэгт 5 оноо	100	

- Дээрх хүснэгтийн 6-с доошгүй категориор 1,450-с доошгүй оноо авсан, нислэгийн цаг нь минимум 400 цаг байхаас 200-с багагүй нь термалд ниссэн байх, мөн дор хаяж 500 нислэг бүртгэгдсэн байх.
- МПХ-ний Ахисан шатны сургалт явуулдаг сургагч багш, ажиглагч, шалгагч нараас дор хаяж 3 тодорхойлолт авсан байх, тэдгээр нь нислэгийн ур чадварыг гэрчлэхээс гадна ялангуяа нисгэгчийн аливааг үнэлж цэгнэх чадвар, төлөвшлийн талаар тусгасан байх.
- Ямар ч аюул осолгүй дараалсан 100 болон түүнээс дээш нислэг үйлдсэн байх.

МПХ-ийн УЗ-өөс томилсон Магадлах комисс:

Нэр: _____Гарын үсэг_____ Он, сар, өдөр _____

Нэр: _____Гарын үсэг_____ Он, сар, өдөр _____

Нэр: _____Гарын үсэг_____ Он, сар, өдөр _____

Хавсралт №3

ПАРАГЛАЙДЕРЫН НИСГЭГЧИЙН ҮНЭМЛЭХ ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН АВАХ АНКЕТ

Шинээр авах эсэх: □ Тийм □ Үгүй Түвшин: P1___ P2___ P3__P4 _ P5__

Үндэсний нисгэгчийн үнэмлэхний дугаар _____ Хүчинтэй хугацаа: _____

МПХ-ны лицензтэй инструкторын зааварчилгаан дор сургалт авч, нисгэгчийн түвшинг инструктор тогтоон баталгаажуулж гарын үсэг зурна. Тухайн түвшний онолын болон ур чадварын шалгалтын хуудсыг хавсаргана.

Инструкторын нэр:_____ Клуб: _____

Гарын үсэг: _____ Он, сар, өдөр: _____

Өргөдөл гаргагчийн

Овог нэр:_____Хүйс: ☐ Эр ☐ Эм

Хаяг:_____

Клуб:_____ Хичээллэж эхэлсэн он, сар, өдөр:_____

CIVL ID: _____

Утасны дугаар:_____

Регистрийн дугаар:_____ Цусны бүлэг: _____

Имэйл хаяг:_____

Яаралтай үед холбоо барих хүний овог нэр:_____

Хаяг: _____

Утасны дугаар:_____

Таны юу болох:_____

ДЭЭРХ БҮХ МЭДЭЭЛЭЛ ҮНЭН ЗӨВ БОЛОХЫГ БАТЛАЖ БАЙНА.

Гарын үсэг: _____Он, сар, өдөр:_____

ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Параглайдераар үйлдэх бүх төрлийн үйл ажиллагаа (сургалт, тандем нислэг, чөлөөт нислэг, тэмцээн уралдаан, үзүүлэх тоглолт, татлагатай гараа, далавч хэрэгслийн худалдаа, худалдан авалт, нислэг буултын талбайн үйл ажиллагаа)-нд оролцох шийдвэрийг _____ миний бие дараах зүйлсийг бүрэн ухамсарлаж, ойлгосны үндсэн дээр сайн дураар гаргаж байна. Үүнд:

1. Би параглайдингийн аливаа үйл ажиллагаа нь аюул эрсдэл учруулж болзошгүй бөгөөд, байгаль цаг уур, техник хэрэгсэл, хүний хүчин зүйлээс шалтгаалан урьдчилан бүрэн тооцоолох боломжгүй өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа болохыг ойлгож байна.
2. Би аюул эрсдэл учирсан тохиолдолд ноцтой гэмтэж бэртэх, хөдөлгөөн-тулгуур эрхтний бэрхшээлтэй болох, хөдөлмөрийн чадвараа алдах, амь нас эрсдэх ноцтой үр дагавар үүсч болзошгүй гэдгийг бүрэн ухамсарлаж байна.
3. Би параглайдингийн аливаа үйл ажиллагаанд өөрийн хүслээр, сайн дурын үндсэн дээр байж болох эрсдэлийг тооцон оролцож байгаа бөгөөд өөрийн аюулгүй байдлын төлөө зөвхөн би өөрөө хариуцлага хүлээнэ гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
4. Би параглайдингийн аливаа үйл ажиллагаанд оролцоход аюулгүй ажиллагаанд нөлөөлж болохуйц эрүүл мэндийн асуудлууд, түүний дотор зүрх судас, цусны даралт, астма, хэт сандрах/түгших эмгэг, үений мултрал, үе мөчний өвчин, шөрмөсний урагдал, хүнд хэлбэрийн харшил зэрэг өвчин байхгүй гэдгээ батлаж байна.
5. Параглайдингийн аливаа үйл ажиллагаанд бэлдэх, оролцох явцад надад тохиолдож болох аливаа эрсдэл, гэмтэл, осол, өмч хөрөнгийн эвдрэл гэмтэл, хохиролд Монголын Параглайдингийн Холбоо, түүний удирдлага, гишүүн клубүүд, тэдний удирдлага, МПХ-ны инструкторууд, тандем нисгэгч нар болон хамтран нисэгч нар хариуцлага хүлээхгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
6. Би энэхүү “Хариуцлагаас чөлөөлөх мэдэгдэл”-ийг анхааралтай уншиж, бүрэн ойлгосон бөгөөд хэн нэгэн хүний дарамт шахалтгүйгээр, сайн дурын үндсэн дээр гарын үсэг зурж байна.
7. Энэхүү мэдэгдэлд гарын үсэг зурахаас өмнө заалт бүрийг тайван уншиж судлах, хөндлөнгийн хууль эрх зүйн зөвлөгөө авах цаг хугацаа надад олгогдсон бөгөөд уг заалтуудыг хүлээн зөвшөөрч буйгаа баталгаажуулж гарын үсэг зурсан болно.
8. Миний бие энэхүү гэрээнд гарын үсэг зурах эрх зүйн бүрэн чадамжтай ба хуулийн өмнө насанд хүрсэн бөгөөд өөрийн асран хамгаалагч (эхнэр/нөхөр)-өөс зөвшөөрөл авч энд гарын үсэг зуруулсан гэдгээ батлаж байна.

Нисгэгчийн Овог, нэр: _____

Нисгэгчийн гарын үсэг: _____Он, сар, өдөр: _____

Эцэг/эх/эхнэр/нөхөр/төрсөн ах/эгч/дүү Гарын үсэг:_____

Овог, нэр: _____